



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 09 сарын 10 өдөр

Дугаар A-14

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” А/348 дугаар тушаалын Даваахүү овогтой Жаргалмаатай холбогдох хэсгийн “Тайваний Тамканг их сургуулийн магистрантурт боловсрол судлалын чиглэлээр” гэж өөрчилсүгэй.
2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Эрдэнэчимэг/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР